

ҮЗЗ-ийн уулзалтын тэмдэглэл

Уулзалтын талаар											
ГС-ийн ҮЗЗ		Монгол Улс			Хуралд санал өгөх эрхтэй гишүүдийн тоо			16			
Уулзалтын №		75			ҮЗЗ-ийн гишүүн бус оролцогчдын тоо, уригдаж ирсэн зочид			10			
Огноо		2017 оны 10 сарын 13			Хурлын зорилгод хүрсэн эсэх (тийм, үгүй)			ТИЙМ			
ХУРЛЫН ДАРГА											
Нэр/ Байгууллага		Овог	Бямбасүрэн			Хурлын үргэлжилсэн хугацаа (цагаар)		3			
		Нэр	Мягмар			Хурал зохион байгуулагдсан газар		ЭМЯ, хурлын А танхим			
		Байгууллага	МҮЭ, Монголын Эрүүл Мэндийн ажилтны ҮЭ-ийн холбооны дарга								
ҮЗЗ-д гүйцэтгэх үүрэг (Тохирох бөглөнө үү) нүдийг		Дарга			x	Уулзалтын төрөл (Тохирох нүдийг бөглөнө үү)		Ээлжит	X		
		Дэд дарга						Ээлжит бус			
		Гишүүн						Хорооны уулзалт			
		Гишүүнийг орлогч				Бусад байгууллагын оролцоо (Тохирох нүдийг бөглөнө үү)		СОНА	X		
Салбар * (Тохирох нүдийг бөглөнө үү)					FRM / PO						
ЗГ	ОУБ	ТББ	Боловсрол	Өвчлөлт бүлгийн хүн ам	Эрсдэлт бүлгийн хүн ам			Шашны Байгууллага	Хувийн Хэвшил	бусад	X
									x	оролцоогүй	

ХӨТӨЛБӨР ТУС БҮРТ ХАМААРАХ СЭДВИЙГ СОНГОНО УУ (Тохирох нүдийг бөглөнө үү)														
ҮЗЗ-ИЙН ЗАСАГЛАЛ, ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ СЭДВҮҮД														
Хөтөлбөр	Ажлын явц	ҮЗЗ-ийн жилийн ажлын төлөвлөгөө болон төсвийг хангах	АСЗ	ҮЗЗ-ийн гишүүнчлэлийн асуудал	Тогтвортой байдал	ҮЗЗ болон хамтрагч байгууллагуудын уялдаа холбоо	Хүйсийн эрх тэгш байдал	Төсөл боловсруулах	УХА, СХА	Тэтгэлэг	Ханалт (Удирдлага, СОНА аудит)	Санхүүжилтийг үргэлжлүүлэн олгох талаар / төслийн II үе / хяналт	Техникийн туслалцаа авах шалгаруулалт	Бусад
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт	x												
Хөтөлбөр #2	Одоо хэрэгжиж буй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийн явцын талаарх танилцуулга, асуулт хариулт	x									x			
Хөтөлбөр #3	2018-2020 онд хэрэгжих Глобал Сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн гэрээний хэлэлцээр хийсэн уулзалтын танилцуулга, асуулт хариулт	x						x				x		

№.	Хөтөлбөрийг дурдана уу
Хөтөлбөр #1	Хурлын нээлт, хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулах, өмнөх хурлын шийдвэрийн биелэлт
Хөтөлбөр #2	Одоо хэрэгжиж буй ХДХВ/ДОХ, Сүрьеэгийн төслүүдийн явцын талаарх танилцуулга, асуулт хариулт
Хөтөлбөр #3	2018-2020 онд хэрэгжих Глобал Сангийн дэмжлэгтэй Сүрьеэгийн төслийн гэрээний хэлэлцээр хийсэн уулзалтын танилцуулга, асуулт хариулт

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

Үгүй

Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй

А.Оюунбилэг: Глобаль сангийн дэмжлэгтэйгээр Монгол улсад одоо хэрэгжиж буй төслүүдийн явцын /Хавсралт №1/ талаар товчхон мэдээлэл хүргэе. ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэх төслийн хугацаа 2017 оны 12 сарын 31-нээр дуусгавар болох бөгөөд үйл ажиллагаанууд хэвийн явагдаж байна. Үүнд бидний анхаарлыг татаж буй гол асуудал бол 12 сарын 31-ны байдлаар төслийн санхүүжилтыг бүрэн зарцуулсан байх ёстой. 9 сарын 15 байдлаар бид ХДХВ/ДОХ, Сүрьеэ өвчинтэй тэмцэх төслүүдийн санхүүгийн үлдэгдлийг хянан үзсэн. Энэхүү ажлын үр дүнд

- Сүрьеэгийн төслийн хувьд 70,000 ам.долларт хийгдэх “Олон нийтэд таниулах мэдээлэл, сурталчилгааны ажил” хараахан эхлээгүй байгаа бөгөөд ЭМЯ хариуцан хийхээр дахин төлөвлөлтөнд оруулсан.
- Түүнчлэн 26,200 ам.доллар төсөвлөгдсөн “Орон гэргүй сүрьеэтэй өвчтөнгүүдэд зориулсан нийгмийн дэмжлэг үзүүлэх” ажил хойшлогдсон боловч энэ жилдээ багтаан зарцуулна гэж найдаж байна. Учир нь энэ чиглэлээр ажиллах СХА байгууллага нь төлөвлөсөн хугацаанаасаа сүүлд сонгогдсон.
- Сорьц тээвэрлэлт дээр 56,000 ам.доллар байгаа бөгөөд үүний хүрээнд дахин төлөвлөлтийг хийгээд оны эцэс гэхэд бүрэн зарцуулсан байна гэж тооцоолж байна.
- ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн Клиникийн 1-4 давхарт агааржуулалтын систем суурилуулах үйл ажиллагаа байна. Энэ нь Сүрьеэгийн 1 жил 6 сарын хугацаатай төслийн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр санхүүжих ба бидэнд оногдсон 3,8 сая ам.доллар дээр нэмэлт 1,2 сая ам.доллар хүссэний дагуу баталгаажилт нь сүүлд хийгдсэн. Тиймээс агааржуулалтын системийн зураг төслийн ажил 8 сарын дундуур бэлэн болсон. Суурилуулах ажил нь өндөр зардалтай учраас заавал тендэр зарлах шаардлагатай болсон бөгөөд ЭМЯ дээр Үнэлгээний Хороо байгуулагдаад энэхүү асуудлыг яаравчлан шийдэхээр ажиллаж байна. Нийт 353,000 ам.долларын төсөвтэй энэхүү ажлыг он дуусахаас өмнө гэрээг нь хийгээд, ядаж урьдчилгаа санхүүжилтыг олгон ажлыг эхлүүлэх шаардлагатай байна.
- Бусад жижиг мөнгөн дүнтэй үйл ажиллагаануудыг цагтаа багтаан хийх болно гэж найдаж байна.

Нийтдээ **600,000 ам.долларын** дүнтэй үйл ажиллагаа хүлээгдэж байна.

ХДХВ/ДОХ-ын чиглэлээр 9 сарын 15-ны байдлаар **415,000 ам.долларын** өртөгтэй ажлууд хүлээгдэж байна.

- Үүнээс хамгийн том нь 271,000 ам.долларын өртөгтэй дахин төлөвлөлтөөр баглагдсан БЗХӨ-ний тархалт өндөртэй 10 аймаг, УБ хотын 1 дүүрэгт халдварыг эрт илрүүлэх, оношлох ажил юм. Энэ ажил эхэлсэн бөгөөд шаардлагатай оношлууруудыг Глобаль Сан нийлүүлж байгаа ба бусад шаардлагатай санхүүжилтыг хуваарилаад шилжүүлсэн байгаа.
 - **Харуудан тандалтын судалгаа:** Энэ судалгаа 2016 онд хийгдэх ёстой байсан боловч энэхүү судалгааг хийх удирдах зөвлөл байгуулах ЭМ-ийн Сайдын тушаал 2016 оны 11 сарын 28-нд гарсан ба түүний дараа ажлын хэсэг хуралдаад, судалгааг хариуцаж явуулах байгууллагуудаа зарлан сонгон шалгаруулалтыг хийсээр байгаад одоо нэг протокол бүрдээд хийгдэх болсон. Үүн дээр гарын үсэг зурагдаагүй хүлээгдэж байгаа нь төслийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг гаргадаг ганц судалгаа тул зайлшгүй хийх шаардлагатай. Энэхүү Судалгааны ажлын хэсгийн даргаар НЭМГ-ийн дарга Д.Ганцэцэг, ЭМЯ-ны ХДХВ/ДОХ, сүрьеэгийн асуудал хариуцсан мэргэжилтэн А.Өнөржаргал нар байгаа бөгөөд энэ тал дээр ихээхэн анхаарал хандуулан ажиллана гэж найдаж байна.
 - Бусад үйл ажиллагаанууд бага мөнгөн дүнтэй ба 2017 ондоо багтаан хийж амжих болно гэж найдаж байна.
- Үлдсэн хугацаанд төлөвлөсөн гол том ажил бол Тэмбүүгийн оношлогоо, эмчилгээ, хүний нөөцийн чадавхийн судалгаа хийгдсэн. Энэхүү судалгааны тайлан ирсэний дагуу үүний талаар зөвшилцөх уулзалтыг нилээд өргөн хүрээтэй зохион байгуулах нь зүйтэй гэсэн бодолтой байна. Учир нь Тэмбүү, Төрөлхийн тэмбүүгийн талаар судалгаан дээр анхаарууштай нилээд зүйлс судалгааны дүн дээр харагдаж байсан .Энэ тал дээр ЭМЯ, ҮЗЗ дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллах байх гэж найдаж байна.
- Өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн төслүүдийн үр дүнгийн талаар 2017 ондоо багтаан хамтрагч талуудын Форум хийх шаардлагатай байгаа бөгөөд ҮЗЗ хамтран ажиллана гэж найдаж байна.
- 2018-2020 онд хэрэгжих ДОХ, сүрьеэгийн төслүүдийг Глобаль Сан Төсөл Батлах Хороонд хүлээлгэн өгсөн байгаа ба 11-р сард сард хариу нь гарах болно.
- Одоо хэрэгжиж буй төслүүдийн ханган нийлүүлэлтийн талаар ЭМ-ийн Сайдын тушаал гаргаж хуваарилдаг ба 2017 оны 6 сард ЭМЯ-ны мэргэжилтэнд өгсөн боловч хариу өдийг хүртэл ирээгүй байна. Тиймээс тэрхүү тушаалд шинээр ирж буй тоног төхөөрөмжийг нэмж оруулах үүднээс тушаалыг түр буцаан авсан

	<ul style="list-style-type: none"> ➤ Хүний нөөцийг сургах ➤ Алслагдсан орон нутгаас сорьц тээвэрлэх ажилд 56,000 ам.доллар гэж байна. ➤ Сурталчлан таниулах ажил яагаад хийгдээгүй байна вэ? <p>Хэрэв та бүхэн одоо тайлбар өгөх боломжгүй бол бидэнд дараагийн хурал гэхэд энэ талаар бүхий л мэдээллийг өгч тайлбарлах хэрэгтэй. Эдгээр ажлуудын үр дүнг бидэнд тайлагнах хэрэгтэй. Бид юуны төлөө энд ажлаасаа цаг гарган ирж байгаа билээ.</p>	
ХӨСҮТ	<p>Д.Нямхүү: ДОХ-ын асуудал дээр ЭМЯ дээр бичиг баримт баталгаажуулалтын улмаас ажил явахгүй байна. Түүнчлэн Сүрьеэгийн Клиникийн агааржуулалтын систем солих асуудал ЭМЯ дээр хичнээн сар хүлээгдэж байна. 8 сараас хойш яригдаж байгаа боловч тендер нь өдийг хүртэл зарлагдаагүй нь их өндөр санхүүжилттэй ажил хоцорч байгаатай адил болж байна.</p>	
ТБ	<p>Л.Бямбасүрэн: Энэ асуудал бол ТНБД-ын хуулиар олгогдсон эрхийн дагуу тушаал гарган Үнэлгээний хороо байгуулан тендер зарладаг. Миний хувьд эдгээр төсөл хөтөлбөрүүдийг хариуцаж буйн хувьд ажил үүргийнхээ дагуу өөрт хамааралтай удирдамж, шийдвэрүүдэд батлаад явж байна. Энэ талаар А.Оюунбилэг зохицуулагч тодорхой хэлэх биз.</p>	
ХЗН	<p>А.Оюунбилэг: Одоо хэрэгжиж буй ДОХ, сүрьеэгийн төслүүд эхлэх хугацаанаасаа хожуу эхэлсэн учир нь ЗГ-тай хийгдэх гэрээ хүлээгдсээр 1,2 улирлаар хоцорч эхэлсэн. Түүнчлэн 2016 оны 7 сарын 1-нээс 10 сарын 10 хүртэл ДОХ, сүрьеэгийн төслүүд зогсонги байдалтай байсан. Учир нь санхүүгийн гэрээний гарын үсэг зурагдахгүй удсанаас хойшлогдсон. Тиймээс бид эдгээр алдсан хугацаагаа нөхөхийн тулд ажиллаж байна. Урд нь хэлж байсанчлан эдгээр төслүүдэд жилд нийт 700 гаруй үйл ажиллагаа төлөвлөгдсөн байдаг бөгөөд бид жилийн 365 хоногийг алгасалгүй 1 өдөрт ядаж 1 үйл ажиллагааг дуусгах шаардлагатай байдаг. Тэдгээр нь тухайн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан харилцан адилгүй хугацаатай байдаг. Тиймээс эрхэм гишүүд та бүхэн бидний ажилд дэмжлэг байнга үзүүлж байгаасай гэж хүсэж байна.</p>	
ТБ	<p>Н.Амарсайхан: Би С.Алтанцэцэг болон Д.Ганчимэг гишүүдтэй санал нэг байна. Бидэнд тайлан явуулах хэрэгтэй байна. Ер нь хурлаар ямар үйл ажиллагаанд хэдий хэмжээний санхүүжилт гаргасныг сонсож байж бид тодорхой хэмжээний шийдвэр гаргах боломжтой болж, мэргэжил арга зүйгээр дэмжих боломжтой болох тул тэр горимруугаа шилжүүлмээр байна. Тайланг цахимаар ирүүлэхийг тань дэмжиж байна. Төслийн зарим үйл ажиллагаа гадны хүчин зүйлээс хамааран доголдож байгааг ойлгож байна. Харин ямар, ямар үйл ажиллагааг хэн, ямар байгууллага хэрхэн хийсэн, түүний үр дүн ямар түвшинд явж байгаа гэдгийг сайтар тайлагнаад явуулах хэрэгтэй байна. Ингэснээр ажлаа хийхгүй байгаа ЭМЯ болон бусад байгууллагад бид хамтран дэмжлэг үзүүлэх бололцоо бүрдэх болно. Түүнчлэн Ажлын алба ч бас үүнд анхааран ажиллаж тайлангаа гаргах хэрэгтэй.</p>	
ХЗН	<p>А.Оюунбилэг: Бид өнөөдрийн байдлаар 38 СХА-тай хамтран ажиллаж байна. Бид тайлангаа ҮЗЗ-д байнга тайлагнаж байгаа. Та бүхэнд өөр ойлгомжгүй асуудал байвал ХЗН-тэй холбоо бариад нарийвчилсан мэдээллүүдийг авах бүрэн боломжтой. Харин бид энд ирээд 700 гаруй үйл ажиллагааг тайлбарлаж үнэндээ амжихгүй. Түүнчлэн одоо хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд 2 том болзолт нөхцөл Глобал Сангаас авсан. ДОХ-ын төсөл 2015 онд, Сүрьеэгийн төсөл дээр 2016 оны 7 сарын 1-нээс амласан ёсоор бид дараах баримт бичгүүдийг төсөл эхэлснээс хойш 3 сарын дотор өгөх ёстой байсан боловч өдийг хүртэл хэрэгжээгүй, бидний хяналтаас гарсан асуудал болоод байна. Энэ нь:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шилжилтийн үеийн төлөвлөгөө 2. Үндэсний хэмжээний хяналт, шинжилгээ үнэлгээний төлөвлөгөө <p>Одоо бид 2018-2020 онд хэрэгжүүлэх 2 төслүүд дээрээ дахин дээрх 2 болзолт нөхцлөө авч байна. ЭМЯ-ны зарласнаар Шилжилтийн үеийн төлөвлөгөө боловсруулсан нь шаардлага хангаагүйг бид мэдэгдсэн. Тиймээс ҮЗЗ-ийн зүгээс иймэрхүү илүү чухал ач холбогдолтой ажлууддаа илүү их анхаарал хандуулан, дэмжлэг үзүүлээсэй гэж хүсэж байна.</p>	
Шашны байгуулагч а	<p>Ж.Одгарь: Миний хэлэх санал бол Хяналтын самбарыг сайжруулах ажлыг ҮЗЗ хариуцан хийгээд төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилттэй холбоотойгоор</p> <ol style="list-style-type: none"> 1. Шилжилтийн үеийн төлөвлөгөө 2. Үндэсний хэмжээний хяналт, шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах ажилд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй гэдгийг ойлгож авсаны үндсэн дээр МУ-ын бодлогын баримт бичгийг ЗГ, хууль, хяналтын байгууллагаас шаардах ёстой байгааг харлаа. <p>Түүнчлэн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажил дотооддоо ч гадааддаа ч ямар ч мэдээлэл байхгүй байна. ҮЗЗ гэж юу вэ гэдгийг мэдэх хүн бараг байхгүй байна. Гэхдээ бид мэдэгдэхдээ гол нь биш үндэсний хэмжээний ийм үйл ажиллагаа, том хөтөлбөрүүдийг явуулж байгааг олон нийтийн байгууллагад мэдэгдэх хэрэгтэй. Мэдээж эмнэлгийн байгууллагуудаар тийм шинжилгээг өгнө, тэдгээр газруудад санхүүжилт өгнө гэж байгаа нь зорилтот бүлгийнхээ хүмүүст л мэдээлэл очиж буй хэрэг юм. Тиймээс өвдсөн ч, өвдөөгүй ч энд ийм үйл ажиллагаа явуулдаг гэдгийг гадагшаа хэвлэл мэдээллийн байгууллагуудыг</p>	

Энэхүү уулзалтаар бид чадварлаг, өндөр шаардлагатай байгууллагын орон нутгийн ҮЗЗ-г байгццлан ажиллаж байгаагийн хувьд бие биеэ ойлгон, нягт хамтын ажиллагаатай ажиллах ёстой гэдгийг сайтар ойлгон авснаа дуулгах нь зүйтэй.

Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга

ХЗН	<p>А.Оюунбилэг: Миний хувьд ҮЗЗ хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн талаар хамгийн их мэдээллийг авч байдаг бөгөөд ХЗН-ийн зүгээс мэдээллийг байнга ҮЗЗ-д өгч, би өөрөө байнга хүмүүст тайлбарласаар эдгээр мэдээллүүдийг бүгд л мэдэж байгаа гэсэн ойлголттой болсон байна. Тиймээс ҮЗЗ-ийн гишүүд та бүхэнд ямар нэг ойлгомжгүй асуудал байвал бидэнд урьдчилан мэдэгдэж тухайн асуудлын хүрээнд ХЗН мэдээлэл боловсруулж хүргэх нь илүү үр дүнтэй байх болно.</p> <p>Түүнээс гадна ҮЗЗ-ийн гишүүд төсөл хөтөлбөрийн талаар ЭМЯ-ҮХА-тай тогтмол уулзан, санал солилцож, төсөл хөтөлбөрүүдийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай болохоос ХЗН-ийн зүгээс бичиг гарган шийдвэрлүүлэх гэдэг нь утгагүй хэрэг юм.</p>
Шашны байгуул ага	<p>Ж.Одгарьд: Та бүхэн Олон улсын хэмжээний гэрээний хэлэлцээрийн уулзалтанд амжилттай оролцон, цаашид хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийг нааштайгаар шийдэхэд нөлөөлөн үр дүнтэй ажиллаад ирсэнд тань талархал илэрхийлье. Төсөл хөтөлбөрүүдийн зарцуулагдаагүй санхүүжилтыг хэрхэн зарцуулах талаар мэдээлэл өгнө үү.</p>
Залуусын байгуул ага	<p>А.Нямдорж: Бид 2016 оны илүүдэл санхүүжилтын асуудлыг өөр зүйлд зарцуулах хүсэлтийг илгээн зөвшөөрлийг авсан. Тиймээс энэхүү төслүүд хэрэгжиж дуусахад бид бүхий л санхүүжилтийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж дуусгах тал дээр талууд хамтран ажиллах хэрэгтэй.</p>
ХӨСҮТ	<p>Д.Нямхүү: Энэ төсөл хөтөлбөрүүдийн 60% гаруй нь тоног төхөөрөмж, ханган нийлүүлэлтэнд зарцуулагдах бөгөөд үүнийг дагалдсан үйлчилгээ, үйл ажиллагааг гүйцэтгэх чадвартай гэдгийг харуулж, батлуулж чадсандаа туйлын сэтгэл хангалуун байна. Түүнийг хамгаалах ажил ихэд төвөгтэй байсан ба биднээс илүү мэргэжлийн, мэргэшсэн багууд асуултуудыг нарийн тавьж байсан.</p> <p>Түүнчлэн Сүрьеэгийн эмийг ГС-ын журмаар бид захиалан авч чадвал хямд үнээр, өндөр чанартай эмийг худалдан авч чадна. Хэрэв ЭМЯ-аас тендер зарлаж авбал Эм ханган нийлүүлдэг компаниуд ГС шиг хямд үнээр захиалж авч чадахгүйн дээр, тус байгууллага өөрсдийн ашгийг нэмсэнээр Монгол улсад ашиггүй байдал улам нэмэгдэнэ гэдгийг санах хэрэгтэй. Тиймээс энэ хүсэлтийг ЭМЯ-д тавих ажлыг ҮЗЗ зохион байгуулах хэрэгтэй.</p>

Хариулт:

А.Оюунбилэг: Одоогийн хэрэгжиж буй төслүүдийн хувьд үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа тул дахин төлөвлөлт хийх шаардлагатай эсэхийг яг одоо хэлж мэдэхгүй байна. Гэхдээ ГС-аас бидэнд жилд 1 удаа дахин төлөвлөлт хийх эрх өгсөн байдаг. Харин ханган нийлүүлэлтээс мөнгө үлдэх магадлалтай байгаа бөгөөд ГС-аас энэ төрлийн зардлыг өөрсдөө авч үлдэн шилжүүлдэг онцлогтой. Үүний дагуу бид ГС-аас мэдэгдэл хүссэн боловч одоогоор ямар нэг тодорхой хариу ирээгүй байна.

Нэмж хэлэхэд, дөнгөж сая надад “ХӨСҮТ-ийн агааржуулалтын тендер зарлагдсан” гэсэн мессэж ирлээ.

Шийдвэр:

ҮЗЗ-ийн гишүүд ЭМЯ-ны ТНБД болон Олон улсын төсөл хөтөлбөрүүд хариуцсан удирдагчтай байнга уулзан санал солилцож, төсөл хөтөлбөрийн үр дүнд гарах нөлөөллийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны явцыг дэмжин ажиллахын тулд шаардлагатай боломж бололцоог бүрдүүлэн ажиллаж, зохих албан бичгийг ЭМЯ-нд өгөх болон Сүрьеэгийн эмийг ГС-ын журмаар захиалан авах хүсэлтийг ЭМЯ-д уламжлах ажлыг ҮЗЗ-ийн Ажлын Албанд үүрэг болгон өглөө.

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар

Зөвшилцөл	х										
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	<table border="1"> <tr> <td data-bbox="691 1518 1029 1570">Гар өргөх</td> <td data-bbox="1029 1518 1461 1570">х</td> </tr> <tr> <td data-bbox="691 1570 1029 1621">Нууц санал хураалт</td> <td data-bbox="1029 1570 1461 1621"></td> </tr> <tr> <td data-bbox="691 1621 1029 1673">Дэмжсэн></td> <td data-bbox="1029 1621 1461 1673">15</td> </tr> <tr> <td data-bbox="691 1673 1029 1713">Эсрэг></td> <td data-bbox="1029 1673 1461 1713"></td> </tr> </table>	Гар өргөх	х	Нууц санал хураалт		Дэмжсэн>	15	Эсрэг>	
Гар өргөх	х										
Нууц санал хураалт											
Дэмжсэн>	15										
Эсрэг>											
		Санал өгөхөөс түдгэлзэх									

Хөтөлбөр #4 Глобал Сангийн МУ-ыг хариуцсан мэргэжилтэнгүүдтэй уулзсан уулзалтын танилцуулга, асуулт хариулт

Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.

Байхгүй.

Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тийм эсвэл үгүй)>

үгүй

Шийдвэрийг хэрхэн гаргасан талаар				
Зөвшилцөл	х			
Санал хураалт	х	Санал хураалт (Тохирох нүдийг бөглөнө үү)	Гар өргөх	х
			Нууц санал хураалт	
		Дэмжсэн>		15
		Эсрэг>		
		Санал өгөхөөс түдгэлзэх		
Хөтөлбөр #5	Бусад <ul style="list-style-type: none"> • Танилцах ажлын айлчлалын санал • ҮЗЗ-ийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах, • ҮЗЗ-ийн дарга 			
Ашиг сонирхолын зөрчилтэй оролцогчийн нэрийг дурдана уу.				
Байхгүй.				
Ямар нэгэн маргаан гарсан эсэх (тгйм эсвэл үгүй)>				Үгүй
Тавьсан илтгэл, танилцуулгын хураангуй				
Б.Мягмар: ҮЗЗ-ийн дарга Б. Мөнхцэцэгийн түр орлон гүйцэтгэгчээр миний бие Б.Мягмар гишүүдийн 80%-ийн саналаар ҮЗЗ-ийн 72 дахь хурлаар томилогдон ажиллаж эхэлсэн. Миний хувьд өөрийн ажлын ачаалал ихтэй байдаг тул, одоо ҮЗЗ-ийн даргадаа ажлыг нь хүлээлгэн өгөхдөө таатай байх болно.				
Хэлэлцсэн асуудлууд дээр гишүүдээс гарсан санал, тодруулга				
ТБ	Н.Амарсайхан: Дархан, Сэлэнгэ аймгуудын хэмжээнд Сүрьеэгийн тархалт их өндөр байна гэсэн судалгаа гарсаны дагуу ҮЗЗ-ийн гишүүд болох Д.Даваадорж, ЗГ-аас Д.Ганчимэг, Б.Мөнхцэцэг ХЭҮК-ийн Ц.Адъяахишиг, МСНЭ-ийн С.Алтанцэцэг нар чиг үүргийнхээ дагуу газар дээр нь очиж үйл ажиллагаатай нь танилцан бусад гишүүддээ мэдээлэл өгөөчэй гэсэн саналтай байна. Ингэснээр бид дараагийн авах арга хэмжээнийхээ талаар хэлэлцэх боломжтой болно. Дараагийн хуралд 2 цагаас оролцох шаардлагатай байгаа тул та бүхнээс чөлөө хүсье.			
ХЗН	А.Оюунбилэг: Та бүхэн танилцах айлчлалаар явж ирчихээд асуудлыг шийдвэрлэнэ гээд л санал хүсэлтийг авч зөвлөмж гарган ажилладаг нь ажилд хүндрэл учруулдаг. Учир нь бид төлөвлөгөөний дагуу ажил үүргээ гүйцэтгээд явж байхад нэмэлтээр өөр зүйлс хийлгэх санаачлагууд гарч ирээд байдгийг анхаарах хэрэгтэй.			
ТББ	Б.Мөнхцэцэг: <ol style="list-style-type: none"> 1. ҮЗЗ-ийн дүрмийн 5.1.5.2. Бүрэн эрхээсээ татгалзах тухай хүсэлтээ ҮЗЗ-д бичгээр ирүүлэх эрхийн хүрээнд би өөрийн ҮЗЗ-ийн даргаас татгалзсан бичгийг авч ирсэн ба энэ нь 5.1.6.-д зааснаар Дүрмийн 5.1.5.2.-т заасан хүсэлтийг ҮЗЗ хүлээн авч болох бөгөөд энэ нь дарга, дэд даргын ҮЗЗ-ийн гишүүнчлэлийг дуусгавар болгох үндэслэл болохгүй гэж заасны дагуу ҮЗЗ-ийн гишүүнээр цаашид ажиллах болно. 2. ҮЗЗ-ийг хуулийн этгээд болгох тал дээр: Миний бие 2016 оны 2 сараас эхлэн ҮЗЗ-ийн даргаар ажилласан ба ҮЗЗ-г хуулийн этгээд болгох зайлшгүй шаардлагатай гэсэн байр суурьтай байсан. Тиймээс цаашид энэ асуудлыг нарийн судалж ямар нэг дорвитой арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай гэсэн саналтай байна. ЭМЯ-ны дансанд хийхэд ямар нөхцөл байдал үүсээд байгааг бид бүгд мэдэж байна. 			
ТБ	О.Баяр: ТББ-ийн тусгай хуультай байдаг ба тэр хэмжээндээ ажилладаг. Харин ҮЗЗ нь өөрийн зорилго, зорилттой, үндсэн үүрэг, функцтэй орон тооны бус гишүүдтэй ажилладаг тул эдгээр нь эрх зүйн хувьд нийцэхгүй санагдаж байна. Гэхдээ ҮЗЗ-ийн санхүүжилтын асуудал хүндрэлтэй орж ирэх нь цаашид зайлшгүй шийдвэрлэх асуудал бөгөөд ҮЗЗ-ийн гишүүд бид хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай тул хийх зүйлийг тохирох хэрэгтэй.			
Шашны байгууллага	Ж.Одгарьд: Танилцах ажлын хүрээнд А.Оюунбилэг даргын хэлснийг дэмжиж байна. Хяналтын хороо чиг үүргийнхээ хүрээнд төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагаатай танилцах хэрэгтэй болохоос янз бүрийн санал, санаачлага гарган явагдаж буй төлөвлөгдсөн үйл ажиллагаанд элдэв төрлийн бэрхшээл учруулж болохгүй. Түүнчлэн ҮЗЗ-г ТББ болгох шаардлага нь зөвхөн Ажлын Албаны жилийн санхүүжилтыг авахын тулд бол хангалтгүй гэж үзэж байна. Өөр ямар асуудал байгааг харж байж шийдэх хэрэгтэй бөгөөд ТББ-ийн хууль			


	<ul style="list-style-type: none"> • ҮЗЗ-ийн даргын тухай асуудлыг дараагийн 76 дах хурал дээр шийдвэрлэхээр хойшлууллаа. 		
--	--	--	--

ДАРААГИЙН ХУРАЛ(ОГНОО, ХӨТӨЛБӨР)	
Огноо	2017 он
Хэлэлцэх асуудлууд	Хөтөлбөр

Хавсрах материал	Тохирох нүдийг бөглөнө үү	
	Тийм	Үгүй
Оролцогчдын бүртгэл	X	
Хөтөлбөр	X	
Бусад /илтгэлүүд/	X	
Хавсралт 1-10	X	

БЭЛТГЭЛ АЖИЛ(Тохирох нүдийг бөглөнө үү)			
	Тийм	Үгүй	
Хурлын төв, хөтөлбөрийг хурал болохоос 7 хоногийн өмнө хүргүүлсэн эсэх	x		7 хоног
Бүртгэлийн хуудас	x		Хуралд оролцсон бүх хүмүүс
Хурлын тэмдэглэлийг хурал болсоноос 7 хоногийн дотор явуулах	x		7 хоног
Хүргүүлсэн тэмдэглэлд гишүүд саналаа өгөх, нэмэх, батлах	x		Цахим хаягаар
Хурлын тэмдэглэлийг гишүүд болон оролц ирсэн төлөөлөлд хүргүүлж байх	x		ҮЗЗ-ийн цахим хуудсанд 15 хоногийн дотор байршуулах

ТОВЧИЛСОН ҮГ:	
Товчлол	Утга
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ҮЗЗ	Үндэсний Зорицуулах Зөвлөл
ТББ	Төрийн Бус Байгууллага
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
ЭМ	Эрүүл Мэнд

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:			
Нэр>	Л.Номин-Эрдэнэ	Огноо>	2017 оны 10 сарын 17
Албан тушаал>	ҮЗЗ-ийн ажилтан	Гарын үсэг>	

БАТАЛСАН:			
Нэр>	Б.Мягмар	DATE >	2017 оны 10 сарын 17
Албан тушаал>	ҮЗЗ-ийн дарга	Гарын үсэг>	